



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f facebook.com/Rtcc.m0n
globe http://rtcc.mrtd.gov.mn
envelope info@rtcc.mrtd.gov.mn
phone +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 05-р сарын дугаар




“Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ыг олон нийтэд танилцуулан, сурталчлах арга хэмжээ зохион байгуулагдлаа.

“Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ыг олон нийтэд танилцуулан сурталчлах хэрэгжилтийг хангах, статистик мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглахтай холбогдсон төр, хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах, салбарын байгууллагууд хоорондоо мэдээллийг хэрхэн солилцох, салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх цахим орчинг сайжруулж шинэчлэн зохион бүтээх хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулж, шинэчлэн батлагдсан журмын танилцуулга хийлээ.

Арга хэмжээнд ЗТХЯ-ны төлөөлөл, ҮСХ-ны тээврийн салбарын статистикч болон суурь бүтэц эзэмшигч байгууллагуудын удирдлагууд болон хилийн өртөөдийн товарын конторын эрхлэгч нар оролцож салбарын статистик бүртгэл мэдээлэлд тулгамдаж буй асуудлын талаар саналаа солилцож төвийн зүгээс цаашид зөвлөмж гарган ажиллахаар боллоо.



Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.






2019 оны 5 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод тогтмол мэдээлж байна.




2019 оны 5 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 976.3 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.3%-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 10940.7 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

ИНФОГРАФИК




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2019 оны тавдугаар сард 212.4 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2225.3 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/




Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны тавдугаар сард 379.7 мян.тн тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр /2019 оны 5 дугаар сард/



Ачилтаар 2019 оны тавдугаар сард төмрийн хүдэр, нүүрс, барилгын материал, жонш, зэс, молибдений баяжмал, хар төмөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 2116.4 мян.тн ачсан байна.





Төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдийн хөдлөх бүрэлдэхүүнд улсын нэгдсэн тооллого, бүртгэл хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 128 тоот тушаалаар байгуулагдсан хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл тооллогын комисс нь төмөр замын тээврийн салбарын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдийн хөдлөх бүрэлдэхүүнд нэгдсэн бүртгэл тооллого хийх, суурь бүтэц дээр ашиглагдаж байгаа болон ашиглагдаагүй хөдлөх бүрэлдэхүүнийг бодит байдалтай нь тулган, тооллого хийж дүгнэлт гарган ажиллалаа.



№ 016

СЭНГЭГДЭГСЭН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙН

ВАГОНЫ ХЭМЖИГДЭХҮҮН

Вагон	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1





Хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтэц бүртгэлийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.



Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн мэдээллийн санд нийт 480 ачааны вагоны мэдээллийг бүртгэн баяжуулсан.

Суурь бүтцийн бүртгэлийн програмд “УБТЗ” ХНН -ийн Замын 1-р ангийн 17 өртөө зөрлөгийн, замын 6-р ангийн 7 өртөөний, замын 2-р ангийн 5 өртөө зөрлөг, БТЕГ ХХК-ийн 3 өртөө зөрлөгийн нийт 366 салбар замуудыг бүртгэлд хамруулав.




“Төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах” ажлын хэсгийн анхны хуралдаан боллоо.

Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан “Төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан “ОСЖД -ын орнуудын логистикийн бодлого”-ыг судлан, ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгах саналаа боловсруулан ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хянуулахаар хүргүүлэв.



Галт тэрэгний хөдөлгөөний 2019 оны зуны нэгдсэн зурмаг боловсруулж батлалаа.



Галт тэрэгний хөдөлгөөний зуны нэгдсэн зурмагийг боловсруулан төвийн захирлаар баталгаажуулан, хуулбарыг ЗТХЯ болон “УБТЗ” ХНН, “БТЕГ” ХХК, “МТЗ” ТӨХК зэрэг төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллагуудад хүргүүлэн мөрдөн ажиллаж байна.

Мэдээ, мэдээлэл



“ТРАНЗИТ МОНГОЛ - 2019” форумд төвийн удирдлага болон мэргэжилтнүүд оролцлоо.

Монгол Улсын Засгийн газар, Зам тээврийн хөгжлийн яам, Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” ХНН хамтран зохион байгуулсан “ТРАНЗИТ МОНГОЛ - 2019” форумд төвийн удирдлага болон мэргэжилтнүүд оролцлоо.



Төвийн архивын баримтад нэгдсэн тооллого хийж, бүртгэлжүүлэв.

ГТХЗНТ-ийн 2019 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтад улсын үзлэг хийх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төвийн захирлын 2019 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан ажлын комисс төвийн архивын баримтад нэгдсэн тооллого хийж, бүртгэх ажлыг зохион байгуулав.



Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийн 5-р сарын дугаарыг төвийн цахим хуудсанд байршууллаа.

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой “Railway Illustrated”, “Trains”, “Railway Magazine” сэтгүүлийн 5-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.





Дэлхийн хамгийн хурдан галт тэрэгнүүд - 2019

Хүмүүс дэлхийн нэг цэгээс нөгөө цэг рүү аялал зугаалга, албан томилолт зэрэг янз бүрийн шалтгаанаар галт тэрэгээр зорчдог. Аялал жуулчлалын зардлын хувьд нисэх онгоц, автомашин зэрэг бусад тээврийн хэрэгслээс бага байдаг. Энэ дугаарт хүчин чадал, хурдны хувьд дэлхийн хамгийн хурдан галт тэрэгнүүдийг танилцуулж байна.

10. THSR 700T, Тайвань



Тайпей болон Каошюй хотуудын хооронд 2007 оны 1 сард явуулж эхэлсэн байна.

Хамгийн дээд хурд - 300 км/цаг.

Энэ галт тэрэгийг “Kawasaki Heavy Industries”, “Nippon Sharyo” ба “Hitachi” компаниуд хамтран зорчигчийн 12 вагонтай зохион бүтээсэн бөгөөд дээд хурдаа 15 минутанд бүрэн авдаг байна.

9. ETR 500 Frecciarossa, Итали



ETR 500 Frecciarossa бол Италийн Trenitalia компанийн хамгийн хурдан галт тэрэг юм. Милан - Ром - Наплес чиглэлийн маршрутын хооронд зорчих үед хамгийн дээд хурд нь 300 км/цаг хүрдэг. Милан хотоос Ром хүртэл 2 цаг 40 минут зарцуулдаг. Зорчигчдын тав тухтай байдлыг хангахын тулд үнэ төлбөргүй

интернетэд холбогдох WiFi төхөөрөмж суурилуулсан байна. Frecciarossa галт тэрэг нь AnsaldoBreda, Bombardier, Alstom компаниудын консорциум барьсан ба ETR 500 Италийн өндөр хурдны галт тэрэгний орчин үеийн сайжруулсан хувилбар юм.

8. SNCF TGV Duplex, Франц



TGV Duplex нь Францын үндэсний төмөр замын SNCF компани ажиллуулдаг ба TGV бүлийн өндөр хурдны галт тэрэг юм. Галт тэрэгний хоёр давхар бөгөөд 508 зорчигчийн суудалтайгаар Alstom компани үйлдвэрлэсэн. Цагт 320 км хурдлах хүчин чадалтай юм байна.



7. Alstom Euroduplex, Франц

Euroduplex галт тэрэг 2011 оны 12-р сард үйлчилгээгээ эхлүүлсэн. Энэ галт тэрэг нь 1020 зорчигч тээвэрлэж болох бөгөөд Alstom төмөр замын компани Euroduplex галт тэрэгний загварыг зохион бүтээжээ. Euroduplex галт тэрэг нь TGV дуплекс өндөр хурдны галт тэрэгний гурав дахь цуврал бөгөөд 320 км/цаг хурдтай.



Өмнөх 2-р үеийнхээс ялгаатай нь Euroduplex галт тэрэг нь бага жинтэй, аэродинамикийн хөдөлгүүртэй бөгөөд эрчим хүчний бага зарцуулалттай.

6. E5 Цувралын Shinkansen Hayabusa, Япон



E5 цуврал Shinkansen Hayabusa бол өнөөдөр Японы хамгийн өндөр хурдны галт тэрэгний үйлчилгээ юм.

2011 оны 3-р сарын 5-нд Зүүн Японы төмөр замын компани энэхүү галт тэрэгний үйлчилгээг явуулж эхэлсэн. E5 цувралын галт тэрэг нь Токио, Аомори хотуудын хооронд зорчих бөгөөд 320 км/цаг хурдтай.

E5 цувралын Shinkansen нь Токио хотоос Шин-Аомори өртөө рүү 2 цаг, 56 минутад /444.28 миль/ хүрнэ. E5 цувралын галт тэрэгний зүтгүүрийг 15 метр урт хамартай бөгөөд хонгилоор явж байх үед дуу чимээ болон чичиргээ багасгах зориулалттай зохион бүтээжээ.

5. Talgo 350, Испани



Энэ галт тэрэг нь хоёр зүтгүүр, 12 зорчигчийн вагонтой.

Түүнчлэн Испанид "Пато" гэж нэрлэдэг бөгөөд зүтгүүрийн хамар нь нугасны хошуу шиг хэлбэртэй юм байна.

Talgo 350-ийн энэ өвөрмөц дизайн нь даралтын долгионыг зохицуулах боломжтой. Энэхүү галт тэрэг

Мадрид, Барселон хотуудын хооронд зорчдог ба хурд нь 350 км/цаг хүрдэг.

4. Siemens Velaro E/AVS 103, Испани



Velaro E нь Германы Siemens компанийн боловсруулсан Velaro E хурдны галт тэрэгний хувилбар юм. Испанид Velaro хэмээх галт тэрэг нь AVS 103 гэж нэрлэгддэг. Velaro E - хамгийн дээд хурд нь 350 км/цаг. Уг галт тэрэг нь Барселонагаас Мадрид руу 2 цаг, 30 минутын дотор зорчиж болно.

Туршилтын явцад Velaro E 403.6 км/цагийн хурдад хүрсэн.

3. AGV Italo, Итали



Энэхүү өндөр хурдны галт тэрэгний хурд нь 360 км/цаг хүрдэг. AVG Italo бол Европ дахь хамгийн хурдан галт тэрэг юм. Гэхдээ анхны туршилтанд 2007 онд AVG галт тэрэг 573.7 км/цаг хурдыг тогтоосон байна.

2. Harmony CRH 380A, Хятад




“Хятадын төмөр зам” -ын Harmony CRH 380A нь дэлхийд 2 -т ордог хурдан галт тэрэг юм. Энэ цахилгаан галт тэрэгний дээд хурд нь 380 км/цаг хүрч чадна. Анхны туршилтаар 416 км/цаг хурдыг тогтоосон байна. CRH 380A хөнгөн цагаан хайлшин их биетэй, бусад галт тэрэгнүүдээс харьцангуй хөнгөн, зүтгүүр нь загасны толгой шиг хэлбэртэй бөгөөд 494 зорчигч тээвэрлэх хүчин чадалтай.

1. Shanghai Maglev, Хятад

Шанхай хотын Maglev нь дэлхийн хамгийн хурдан галт тэрэг юм. Энэ галт тэргээр “Шанхайн Маглев Тээврийн Хөгжил” ХХК үйл ажиллагаагаа явуулдаг ба Шанхай хотын өндөр хурдны соронзон шугам дээр ажилладаг. Maglev гэдэг нь magnetic - levitation, соронзон орон дахь биетийн хөвөлт гэсэн утга илэрхийлсэн үгсийн товчлол юм. 4 минутад дээд хурд болох 430.9 км/цагт хүрдэг.





 **8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс**

